

Монголын нийгэмд үйлчилдэг ТББ - ын төлөв

“Ашгийн төлөө бус байгууллын эрх зүйн зохицуулалт” сургалт семинарт Иргэний Боловсролын Төвийн захирал Док. Р.Нарангэрэлийн тавьсан илтгэл

ТББ-ын хуулийн 4-р бүлгийн.2, 3-т:

"Нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага" гэж соёл, урлаг, боловсрол, хүмүүжил, шинжлэх ухаан, эрүүл мэнд спорт, байгаль орчин, орчин ахуйн хөгжил, хүний эрх, хүн амын тодорхой бүлэг давхаргын эрх ашиг хамгаалах, энэрлийн зэрэг чиглэлээр нийгмийн тусын тулд үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагыг,

"Гишүүддээ үйлчилдэг төрийн бус байгууллага" гэж өөрийн гишүүдэд үйлчилдэг, тэдний хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үндсэн зорилготой, нийгэмд үйлчилдгээс бусад төрийн бус байгууллагыг

энэ нэр томъёогоор ойлгоно гэсэн байна.

2002 оны 8-р сарын 22-ны байдлаар ХЗДХЯаманд бүртгэлтэй 3200 байгууллагаас Нийгэмд үйлдчилдэг гэж бүртгүүлсэн 2586, гишүүддээ үйлчилдэг гэсэн 614 ТББ байна.

Эдгээр хоёр төрлийн байгжууллагыг одоо үйлчилж байгаа хуулинд ялгаж үзсэн юм төдийлөн байхгүй байна. Татварын зохицуулалт дээр анхандаа нийгэмд үйлчилдэг байгууллага нь арай илүү хөнгөлөлттэй туссан байсан. Тийм ч учраас гишүүддээ үйлчилдэг олон байгууллага өөрсдийгөө нийгэмд үйлчилдэг гэж бүртгүүлсэн байх гэдэг саналыг өчигдөр хүмүүс хэлж байсан. Тийм ч байх. Ямартаа ч монголын нийт ТББ-ын 80 хувь нь нийгэмд үйлчилдэг ТББ юм байна.

ННХ-гээс хийсэн Монголын ТББ-ын лавлах их сайхан ажил болжээ. Энэхүү лавлагаас эхний 250-ийг шинжиж үзэхэд дараах ажиглалтууд харагдаж байна. Нэгдугаарт байгууллагуудыг нийгэмд үйлчилдэг, гишүүддээ үйлчилдэг гэдэг категориор ялгаагүй, бүгдийг дараалуулан харж байж ялгах юм байна. Хоёрдугаарт, энэ лавлахад 2 бус 3 төрлийн байгууллага байна: гишүүддээ үйлчилдэг, нийгэмд үйлчилдэг, бас нийгэмд, гишүүддээ үйлчилдэг гэж. Гишүүддээ үйлчилдэг гэж бүртгүүлсэн 614 байгууллага нь ихэнхдээ мэргэжлийн байгууллагууд /Монголын сувилалчдын нийгэмлэг, Монголын холбоочдын эвлэл, Монголын Аялал жуулчлалын холбоо, Нийгмийн ажилтны нийгэмлэг зэрэг/ байхад нийгэмд үйлчилдэг гэх байгууллага дотор гарцаагүй гишүүддээ үйлчилдэг баймаар байгууллагууд ч харагдах юм. Жишээ нь: улс хоорондын найрамдлын нийгэмлэгүүд, Монголын ахмадын холболл, УБ хот дахь аймаг, сумдын нутгийн зөвлөлүүд, Японд сургууль төгсөгчдийн холбоо, Хувийн хэвшлийн эздийн ажил хэргийг зохицуулан төлөөлөх "Чандмань" холбоо зэрэг. Харин гишүүддээ/нийгэмд үйлчилдэг гэж бүртгүүлсэн байгууллагууд янз бүр байна: Арьс ширний үйлдвэрлэлийн холбоо, Монголын хүүхэд залуучуудын хөгжлийн төв, Монголын элсний волейболын холбоо, Монголын ширээний теннисний холбоо, Залуу лидер клуб, Монголын ажил хэрэгч тахир дутуу иргэдийн холбоо, Монголын орчуулагчдын нийгэмлэг, "ИСЭМ" боловсролын төв, Монголын англи хэлний багш нарын холбоо, Монголын хүнсчдийн холбоо гэнх мэт.

Шинэ Үндсэн хууль батлагдаад 11 жил, ТББ-ын хууль батлагдаад 6 жил болж байна. Энэ хугацаанд ТББ-ын тухай дорвитой судалгаа хийгдэж байсангүй. Энэ семинараар жишээ хийхэд бид тодорхой судалгаан дээр үндэслэсэн юмгүй, цэвэр практик талаас ярьж байна. Харин сүүлийн үед энэ талаар зарим ажил явагдаж байгаа нь сайшаалтай. Харамсалтай нь эдгээр судалгааны материалыг үзэхэд санаанд хүрэх үр дүн харагдахгүй байна.

1. "ТББ-ын иргэний нийгэмд эзлэх социал статус" гэж Монголын социологич, нийгмийн сэтгэл зүйч залуучуудын "АСЛИС" холбоо
2. "Төрийн бус байгууллага судлал" төслийн тайлан" гэж Мэргэжлийн социологчдын "ЗОТОЛ" клуб

3. Судалгааны тайлан /ТББ-ын онлайн мэдээллийн хэрэгцээ/ гэсэн 3 судалгаатай танилцлаа. /тухай бүрийн талаар товч тайлбар өгнө/

Бид цаашид хуулиа боловсронгуй болгож үйл ажиллагаандаа нэмэр болгох зорилготой байгаа нь мэдээж. Тиймээс маш бодит, бие даасан судалгаа зайлшгүй хэрэгтэй нь эндээс харагдаж байна. Жишээ нь 1990 оноос хойш бие даан үйл ажиллагаа явуулж буй ТББ-дад хичнээн хүн ажиллаж байна, өөрөөр хэлбэл хэдэн хүн ажлын байртай, цалинтай болсон, хичнээн хүнд үйлчилгээ үзүүлж байна, хэдий хэмжээний хөрөнгө оруулалт Монголын эдийн засаг, нийгэмд орж ирсэн байна гэдэг судалгаа онц шаардлагатай байна. Нөгөө талаас манай ТББ-д хөгжлийн ямар шатандаа явж байна, үйл ажилаагааг нь улам үр дүнтэй болгоход цаашид ямар арга хэмжээ авах хэрэгтэй байна гэх зэрэг орчин үеийн арга барилаар хийгдсэн судалгаа хэрэгтэй байна.

Өчигдөр энд болсон ярилцлагын мөрөөр хэд хэдэн санал хэлэх нь зүйтэй болов уу гэж бодож байна.

1. ТББ нэр томъёоны хувьд: GOVERNMENT гэдэг үгийг Засгийн газар гэсэн үг, ТББ гэдэг нь үүний кальк буюу хуулсан орчуулга гэж ойлгоод байна. Гэтэл энэ бол Засгийн газар, парламент, орон нутгийн засаг захиргаа зэрэг ТӨРийн бүхий л байгууллагаа хэлж байгаа үг юм. Иргэний боловсролын нэгээхэн том бүлэг нь нөгөө GOVERNMENT гэдэг чинь байдаг. Энэ нь юу үздэг вэ гэвэл төрийн зохион байгуулалт байдаг. Тийм учраас ТББ гэдэг нэр томъёо бол Засгийн газрын бус байгууллага гэсэн үг бишээ.
2. Ирэний хуульд ашгийн бус байгууллагыг холбоо, сан, хоршоо гэсэн хэлбэртэй байж болно гэжээ. Бусад нь яах вэ? Тэхлээр институци гэж нэрлэе гэсэн саналууд гарч байна. Уучлаарай, ТББ гэдэг нэр томъёо чинь өнөөдөр институцийн нэрэнд хүрчихээд байгаа юм биш үү? Энэ чинь нэр томъёо гэхээсээ илүү ОЙЛГОЛТ болчихсон байна. Энэ ойлголтонд холбоо, сан нь хоршоотойгоо, дээрээс нь клуб, хороо, зөвлөл, хүрээлэнтэйгээ багтаад явж байгаа шүү дээ. Дахин шинэ нэр гаргаж түүнд дасч эхэлж байтал бас нэг өөр парламент гарж ирээд солиод орхих юм биш биз?
3. Бүртгэлийн тухайд гэвэл хөдөө орон нутагт байгуулагдаж байгаа ТББ-д орон нутгаараа дамжуулж бүртгүүлэх эрх одоогийн энэ хуулиар олгогдсон байгаа. Хот руу явж зардал чирэгдэл гаргах ямар ч шаардлага байхгүй. Манай ТББ-ыг бүртгэх процедур зөвлөх багшийн өчигдөр ярьж байсан шалгууруудыг хангаж байна гэж үзэж байна: хялбар, хурдан, хямд. ХЗДХЯ бичиг баримтыг хүлээж авснаас хойш 30 хоногийн дотор ТББ-ыг бүртгэж авах үүрэгтэй. Хэрэв энэ хугацаанд албан ёсоор хариу өгөхгүй бол ТББ өөрийгөө бүртгэгдсэн гэж тооцож үйл ажиллагаа явуулах эрхтэй. Үүнээс илүү либерал процедур байх гэж үү?
4. Ажлын хэсгийнхэн зарим тоо баримт дурьдаж байна. Зөвхөн 40 орчим хувь нь ажиллаж байна гэх мэт. ТББ байгуулсан хүн юмуу хэсэг бүлэг хүмүүс ажиллана уу, байна уу, мөнгөтэй байна уу үгүй юу, энэ бол зөвхөн тэдний эрхийн асуудал. Санхүүгийн босго тавих маягийн юм ярих бүр ч утгагүй. Тэр бол энэ хуулийн зарчмын суурь үзэл санаатай шууд зөрчилдөх асуудал юм.
5. Аж ахуйн үйл ажиллагааны тухай. Хэрэв ТББ-д аж ахуйн үйл ажиллагаа явуулаад их орлого олоод эхлэх юм бол мөн чанараа алдана. ТББ бол филантропист үзэл санааны байгууллага. Аж ахуйн үйл ажиллагаа явуулмаар байвал компани байгуулаад ажилла л даа. ТББ-ыг зүгээр байлгаач ээ. Харин зорилгодоо нийцсэн бөгөөд зайлшгүй хэрэгтэй жижиг аж ахуйн үйл ажиллагаа ямар ч тохиолдолд байж л таараа. Жишээ нь, манай байгууллага ТББ-ын менежментийн чиглэлээр сургалт явуулдаг, гарын авлага хэвлэдэг. Сургалтаа бид үнэлж болно, номоо зарж болно. Орлого олж байгаа биз? Энэ бол зорилгод чиглэгдсэн аж ахуйн үйл ажиллагаа. Харин нөгөө ТББ-дад сургалтаа хийхээ хаячихаад онигоо юм уу эротик ном олноор хэвлэж зараад, эсвэл нөгөө сургалтанд оролцсон байгууллагууддаа хуушуур хийж шахаад эхлэвэл болохоо болино биз дээ.
6. Улс төрийн үйл ажиллагааны тухайд: энэ бол маш болгоомжтой хандах асуудал. Манайх шиг улстөржих дуртай нийгэмд бол юуг ч улс төрийн үйл ажиллагаа гэж нэрлэж болно. Тиймээс улс төрийн үйл ажиллагааг хорих юм бол бараг бүгд ТББ-д хаагдах болох вий.

Нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллагын өнөөгийн байдлын тухай ярих байсан би саналаа хэлсэн минь дээрх сэдэвтэй мөн л холбоотой гэж үзэж байгаа шүү.

Эцэст нь хэлэхэд ТББ-ууд харьцангуй богино хугацаанд институцийн хувьд өсөн торниж нийгэмд эзлэх тодорхой орон зайтай байгууллагуудын сүлжээ болжээ гэдгийг хэн хэнгүй

хүлээн зөвшөөрөх байх. ТББ-ын боловсон хүчин туршлагажиж, мэдлэгжиж, чадваржиж байна. Улмаар нийгмийн процесст нөлөөлж чадахуйц хүчин болж байна гэж дүгнэж байна. Өнгөрсөн хугацаанд одоо үйлчилж байгаа хууль маань хэдийгээр хэсэг хэсгээрээ өөр хуулинд шилжсэн, зарим заалт нь үгүй болсон ч үүргээ сайн биелүүлж ТББ-ыг үүсэн бий болж өсөж торниход нь саад учруулаагүй, харин ч хамгаалж, зохицуулалт хийж ирсэн билээ. Иймээс энэ хуулийг боловсронгуй болгох асуудалд маш болгоомжтой, нухацтай хандах нь зөв болов уу гэж бодож байна.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН